



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023. 02.08 № 03/903  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Гүйцэтгэгч сонгох ажиллагааг  
түр түдгэлзүүлэх тухай**

Танай байгууллагаас зарласан ҮСХ/202312001 дугаартай “Статистикийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах программ хангамжийн лиценз” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 2 дугаар багцад оролцсон “Могол сервис” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Захиалагчийн үнэлгээний хороо томилсон шийдвэр;
3. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээний дугаар;
4. Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг;
5. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер (цахим тендер бол холбогдох файл);
6. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
7. Үнэлгээний хорооны тайлан, хурлын тэмдэглэл;
8. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
9. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй тухай мэдэгдлийг оролцогч нарт хүргүүлсэн талаар нотлох баримт;
10. Захиалагч хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт заасан гомдол барагдуулах ажиллагаа явуулсан бол холбогдох мэдэгдэл, хурлын тэмдэглэл;
11. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн журмын 4.6-д заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байх, 4.7-д заасны дагуу тендерт оролцогч нарт энэхүү мэдэгдлийн тухай мэдээлэх арга хэмжээ авахыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 55 дугаар зүйлийн 55.10 дахь хэсэгт зааснаар хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ